

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл хуралдав

2011 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр Санхүүгийн Тогтвортой Байдлын Зөвлөл хуралдлаа. Хуралд Монголбанкны Ерөнхийлөгч Л. Пүрэвдорж, Сангийн сайд С. Баярцогт, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч Б.Жавхлан, Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал Д.Болдбаатар, Монголбанкны Хяналт шалгалтын газрын захирал Б.Лхагвасүрэн, Сангийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Батбаяр нар оролцов.

Уг хуралдаанаар Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны ажлын уялдаа холбоог шинэ төвшинд гаргахаар хэлэлцэн тохиролцож, эдийн засгийн өндөр өсөлтийн үед мөнгөний болон сангийн бодлогын уялдааг хангах, дэд бүтцийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх оновчтой хувилбарыг тогтоохоор тохиролцож хамтарсан ажлын хэсэг байгуулахаар шийдвэрлэлээ. Уг ажлын хэсэгт дээр дурдсан байгууллагуудаас гадна Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны удирдах ажилтнууд орсон нь макро эдийн засгийн бодлого, түүний уялдаа холбоог сайжруулах юм.

Хямралын дараах үед дотоодын арилжааны банкууд дээр чөлөөт эх үүсвэр ихээхэн хэмжээгээр төвлөрсөн. Энэ хөрөнгийг төлөвлөөд байгаа хөрөнгө оруулалтад ашиглах, эдийн засаг руу үр ашигтай байдлаар оруулах хамгийн үр ашигтай хувилбар нь Засгийн газрын дунд болон урт хугацааны үнэт цаас гаргах явдал юм. Энэ нь олон улсын зах зээл дээр үнэт цаас гаргахаас хялбар, мөн гадаад өрийн дарамтыг багасгах, илүүдэл эх үүсвэрийг эргэлтэнд оруулан эдийн засгийн өсөлтийг хангах, мөнгөний болон сангийн бодлогын эдийн засгийн уялдаа холбоог сайжруулах давуу талуудтай болно. Засгийн газрын үнэт цаасыг гаргах техникийн асуудалд Монголбанк, Сангийн яаманд туслан ажиллахаар тохиров.

Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран Банк бус санхүүгийн байгууллагуудад хяналт шалгалт хийх, мэдээлэл харилцан солилцох үйл ажиллагааг эрчимжүүлэхээр тогтлоо.